



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 1/20

Улаанбаатар хот

Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалт, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160 дугаар тушаал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2022 оны “Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А63 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хачгаар дамжих халдварын идэвхжлийн үеийг угтуулан 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд халдвараас сэргийлэх, эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласугай.
2. Харьяа ӨЭМТ-ийн дарга, тасгийн эрхлэгч нарт даалгах нь:
 - 2.1. Хачгаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх талаар иргэд, аж ахуй нэгж, байгууллага, зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, хэвлэл мэдээлэл олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлах,
 - 2.2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу сэжигтэй тохиолдлын үед шаардагдах эм, урвалж, халдваргүйжүүлэх бодис, сорьц цуглуулах, тээвэрлэх хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн, бэлэн байдлыг ханган, зааврын дагуу ажиллах,
 - 2.3. Хачгаар дамжих халдварын эсрэг дархлаажуулалтын хамралтын мэдээг тархвар судлагч О.Төртулга, 06 дүгээр сарын 30-ны өдөр багтаан Эрүүл мэндийн Сайдын 2019 оны 611 дүгээр тушаалын ЭМТ-313.6 хавсралтын дагуу гаргаж, Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний

3 170 7031028

хэлтэс (мэргэжилтэн У.Наранцэцэгт)-т ulam.naraa2404@gmail.com
цахим хаягаар ирүүлэх,

- 2.4. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв, дүүргийн холбогдох хэлтэс, албадтай хамтран ноос ноолуур боловсруулах, мал нядлах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн ажилчид болон эрсдэлд бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, сайн дурын дархлаажуулалтад хамруулах,
 - 2.5. ӨЭМТ болон тасаг нэгжийнхээ эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хачигт халдварын талаар сургалт зохион байгуулах.
 - 2.6. Хачигт халдварын тохиолдол бүртгэгдсэн үед тухайн байгууллагын тархвар судлагч Г.Халиунаа, Нийслэлийн Эрүүл мэндийн газар (мэргэжилтэн Г.Дашдаваа 88013075)-т шуурхай мэдээлэх, түргэвчилсэн үнэлгээг хийж, илтгэх хуудсыг ирүүлэх.
3. Иргэдэд чиглэсэн зөвлөмж, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн ажилтан /Н.Мөнгөнцацралт/-д үүрэг болгосугай.
 4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ